



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 27 өдөр

Дугаар А/37.

Ховд

Хязгаарлалт тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын “а” заалт, 30 дугаар зүйлийн 30.1.16, 30.1.17 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Засгийн газрын 2020 оны “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” 238 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын 2021 оны 04 дүгээр тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улаанбаатар хотоос хот хоорондын нийтийн тээврийн автобусаар зорчин ирсэн 2 иргэний коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын түргэвчилсэн болон PCR шинжилгээний хариу эерэг гарсантай холбогдуулан Ховд аймгийн нутаг дэвсгэрээс гарах, орох иргэд, автомашины хөдөлгөөнийг 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 20.00 цагаас 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 08.00 цаг хүртэл түр хугацаанд хязгаарласугай.

2. Иргэд болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хязгаарлалт хийж ажиллахыг аймгийн Онцгой комиссын орлогч, Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газар /дэд хурандаа Б.Алтанбадралт/, Цагдаагийн газар /цагдаагийн хурандаа Э.Даваасүрэн/, Авто тээврийн төв /Н.Ирэхзаяа/ сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

Б/Заб-А/37-Бо  
02 0209